



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/05

Мөрөн сум

**Хөрөнгө бүртгэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/32 дугаар захирамж, 2019 оны А/375 дугаар захирамж, хөрөнгө хүлээн авах комиссын 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 202212052-142 дугаар актыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Монтех дистрибьюшн” ХХК-ийн нийлүүлсэн 134,970,000.00 (Нэг зуун гучин дөрвөн сая есөн зуун далан мянган) төгрөгийн өртөгтэй XCMG GR-180 загварын автогредерийг Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын эзэмшилд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу холбогдох дансанд бүртгэж, орлогын баримт, үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх ҮХ-1 маягыг ирүүлэхийг Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын дарга (М.Батцогт)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын боловсрол, соёлын байгууллагын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн (Ч.Лхагвамядаг)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ДОЛЖИНСОРОГДОГ



d:/tushaal

6712010039